



- 7.2.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүрэг гүйцэтгэнэ.
- 7.2.10. Төлөөлөн удирдах зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор Төлөөлөн удирдах зөвлөл томилно.
- 7.2.11. Нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хууль, энэ дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллаганы журамд заасан үүрэг гүйцэтгэнэ.
- 7.2.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүд, гүйцэтгэх захирал болон компанийн дүрэмд заасан бусад этгээдийн санаачлага, шаардлагаар нэмэлт хурал хуралдуулна.
- 7.2.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь тогтоол байх бөгөөд тогтоолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 7.2.14. Хуралдах нөхцөлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.
- 7.2.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь үйл ажиллагааны журмаар тогтоосон эрх хэмжээний дотор компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах болон компанийн эрх ашгийг төлөөлөх зэргээр компанийн нарийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах эрхтэй байна.
- 7.2.16. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд Компанийн тухай хууль, энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 7.2.17. Компанийн тухай хууль болон энэ дүрэмээр тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүд санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.2.18. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд гишүүн бүр нэг саналын эрхтэй байна. Хуралд оролцож байгаа гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 7.2.19. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг компанийн хуульд заасан журмын дагуу нарийн бичгийн дарга хөтөлж, хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурахаас татгалзсан гишүүн бичгээр тайлбар гаргана.
- 7.2.20. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гарах шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

7.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо

- 7.3.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх байнгын хороодтой байх бөгөөд тэдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.
- 7.3.2. Энэ дүрмийн 7.3.1-д заасан хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, компанийн тухай хууль, дүрэмд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.
- 7.3.3. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна. Үүнд:



- а) Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн ёуад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- б) Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- в) Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- г) Их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- д) Компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал;

7.3.4. Нэр дэвшүүлэх хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- б) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд компанийн тухай хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- в) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- г) Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- д) Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцлийг боловсруулах;
- е) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- ж) Өмнө нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан этгээдийн нэрийг Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах;

7.3.5. Цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлэх бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- б) Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- в) Компанид мөрдөж буй ажлын үр дүнтэй холбогдсон урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

7.4. Гүйцэтгэх захирал:

7.4.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч нь гүйцэтгэх захирал байна.

7.4.2. Гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан контрактын гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.



- 7.4.3. Гүйцэтгэх захиралтай байгуулах контрактын гэрээг Хөдөлмөрийн хуульд заасан журмаар байгуулах бөгөөд уг гэрээнд түүний эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 7.4.4. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрснөөр өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.
- 7.4.5. Гүйцэтгэх захиралд их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх, компанийн үл хөдлөх хөрөнгө худалдах, хөрөнгө барьцаалах, хөрөнгө оруулалтын ба зээлийн гэрээ байгуулах болон компанийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх зөвшөөрлийг Төлөөлөн удирдах зөвлөл олгоно.
- 7.4.6. Гүйцэтгэх захирал нь энэ дүрмийн 7.4.5-т зааснаас бусад (өмч хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хангамжийн материал, сэлбэг хэрэгслэл, түлш шатахуун худалдан авах, хөрөнгийн их болон урсгал засвар хийх, үйлчилгээ үзүүлэх зэрэг компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хамаарах хэлцэл хийх, компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах, өмч хөрөнгө актлах, данс бүртгэлээс хасах, мөнгөн хөрөнгийн бэлэн ба бэлэн бус гүйлгээ хийх, эрх бүхий албан тушаалтныг ажилд томилох, чөлөөлөх, компанийн орон тоо, цалингийн сангийн хэмжээ, компанийн ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах болон төр, захиргаа, хуулийн байгууллагад компанийг төлөөлөх зэрэг) бүрэн эрхийн асуудлаар компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 7.4.7. Гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлж болно. Энэ тохиолдолд багийн санал болгосон ажиллах журам, гэрээний төслийг Төлөөлөн удирдах зөвлөл хэлэлцэн санал нэгтэй баталсан байна.
- 7.4.8. Гүйцэтгэх удирдлагын баг болон гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл хэдийд ч гаргах эрх эдэлнэ.
- 7.5. Эрх бүхий албан тушаалтан:**
- 7.5.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн ерөнхий менежер, эрх зүйн менежер, албаны дарга (захирал), ерөнхий нягтлан бодогч, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 7.5.2. Энэ дүрмийн 7.5.1-д заасан эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасан эрх, үүрэг, хариуцлага хүлээж ажиллана.

НАЙМ. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

8.1. Аудиторын хяналт:

- 8.1.1. Аудитын тухай Монгол улсын хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөл аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтооно.
- 8.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудиторын эрх үүрэг, хариуцлага, аудитор төлөх хөлсний хэмжээг заана.



- 8.1.3. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
- 8.1.4. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.
- 8.1.5. Ээлжит бус шалгалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, түүний аудитын хороо болон компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн шаардлагаар хэдийд ч хийж болно.
- 8.1.6. Аль нэг хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг компани хариуцаж төлнө.
- 8.1.7. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
- 8.1.8. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримтыг танилцуулах үүрэгтэй.
- 8.1.9. Энэ дүрмийн 8.1.8-д заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтны буруугаас аудитын байгууллагын буюу аудиторын ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай этгээдээр төлүүлэх шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- 8.1.10. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ба төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй.

ЕС. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

- 9.1. Компанийг Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах болон өөрчлөх замаар өөрчлөн байгуулна.
- 9.2. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана. Үүнд:
 - 9.2.1. Компанийг татан буулгах нөхцөл байдал бий болсон, эсхүл удаан хугацаагаар үргэлжилж байгааг харгалзаж хувьцаа эзэмшигчдээс гаргасан саналыг авч хэлэлцээд санал нэгтэй шийдвэр гаргасан;
 - 9.2.2. Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;
 - 9.2.3. Компанийг татан буулгахыг хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх зөвшөөрсөн;
 - 9.2.4. Иргэний хууль, компанийн тухай хуульд заасан бусад үндэслэл.
- 9.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буугдаж байгаа бол компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэж байгаа эд хөрөнгийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.
- 9.4. Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд оролцоно.



- 9.5. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид, эсхүл зээлдүүлэгчид хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө.
- 9.6. Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчдэд мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй байна.
- 9.7. Татан буулгах комисс нь нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгөийн мэдээ, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах балансыг гаргах бөгөөд уг балансыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.
- 9.8. Татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа нэхэмжлэгч (зээлдүүлэгч)-дэд бичгээр мэдэгдэнэ.
- 9.9. Компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс компанийн бусад эд хөрөнгийг худалдаж болно.
- 9.10. Татан буулгах комисс зээлдүүлэгч болон бусад үүрэг гүйцэтгэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгө, эсхүл тэдгээрийг худалдаж борлуулсан орлогыг хувьцаа эзэмшигчдэд Компанийн тухай хуульд заасан дарааллын дагуу тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлж хуваарилна.
- 9.11. Компанийн бүх эд хөрөнгийг хуваарилсаны дараа татан буулгах комисс компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг хүргүүлнэ.
- 9.12. Компани нэгдэх, өөрчлөн зохион байгуулснаас үйл ажиллагаа нь дуусгавар болж байгаа тохиолдолд бүртгэх байгууллага болон олон нийт, зээлдүүлэгчдэд хүргэх мэдэгдэлд компанийн эрх үүргийг шилжүүлэн авсан хуулийн этгээдийн нэрсийг заана.
- 9.13. Хуваагдсаны улмаас компанийн үйл ажиллагаа дуусгавар болсон бол хуваах балансын дагуу компанийн эрх, үүргийг шилжүүлж авсан компани тус бүрийн нэрсийг мэдээлнэ.
- 9.14. Бүртгэх байгууллага компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

АРАВ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 10.1. Хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор баталж, бүртгэх байгууллагад бүртгүүлснээр энэхүү дүрэм хүчин төгөлдөр болно.
- 10.2. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 10.2-т зааснаар төгөлдөр болно.